


ИНТЕРНЭТ БАНКААР БҮРТГЭЛГҮЙ ТӨХӨӨРӨМЖӨӨС НЭВТРЭХ ГАРЫН АВЛАГА

АГУУЛГА


1. БҮРТГЭЛГҮЙ ТӨХӨӨРӨМЖӨӨС НЭВТРЭХ
2. ХАНДСАН ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТАА ХАРАХ

1. Бүртгэлгүй төхөөрөмжөөс нэвтрэх

Харилцагч та интернэт банк/www.egolomt.mn/ руугаа тухайн төхөөрөмжөөс/веб хөтөч/ анх удаа нэвтэрч байгаа тохиолдолд таниас нэг удаагийн OTP нууц код асуух цонх гарч ирнэ. Хэрэв та нэвтрэхдээ e-токен төхөөрөмж эсвэл Google authenticator ашиглан давхар баталгаажуулдаг бол нэг удаагийн OTP нууц код асуухгүйгээр шууд нэвтрэнэ.




Алхам №1: Нэвтрэх хэсэгт та өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгээ хийнэ.



Алхам №2: Тухайн төхөөрөмжөөс/веб хөтөч/ анх удаа нэвтэрч байгаа тохиолдолд энэхүү цонх гарч ирнэ.

Алхам №3: Банканд бүртгэлтэй утасны дугаар эсвэл имэйл хаягаа шалган аль нэгийг нь сонгон илгээх товч дарна.

Алхам №4: Аль сүвгийг сонгосноос хамаарч 4 оронтой нэг удаагийн OTP нууц код ирнэ.



Алхам №5: Хэрвээ та тус төхөөрөмжөөс байнга нэвтрэх бол “Би тус төхөөрөмжийг байнга ашигладаг” сонголтыг хийгээд, ирсэн 4 оронтой нэг удаагийн OTP нууц кодыг оруулаад нэвтрэх товчийг дарна.

Санамж:

- Таны имэйл хаяг **Yahoo** бол нэг удаагийн OTP нууц код илгээх боломжгүй болохыг анхаарна уу.
- Хэрэв таны утасны дугаар/имэйл хаяг солигдсон бол Смарт банк аппликэйшний хувийн тохиргоо цэсээр орж шинэчлэх эсвэл Голомт банкны өөрт ойр байрлах салбар, Харилцагчийн үйлчилгээний төвд /18001646/ хандан шинэчлүүлнэ үү.
- Нэг удаагийн OTP нууц код ирэхгүй 60 сек болсон тохиолдолд Дахин илгээх товчийг дарж дахин илгээнэ үү.
- OTP нууц кодыг 5 удаа буруу оруулсан тохиолдолд дахин OTP илгээх боломжгүй болох ба ийм үед Интернэт банкны нэвтрэх нүүрний Мартсан цэсээр орж Нууц үгийн блок гаргах үйлдэл хийнэ үү.

2. Хандсан төхөөрөмжийн жагсаалтаа харах

Харилцагч та интернэт банк руугаа амжилттай нэвтэрсний дараа хандсан төхөөрөмжийнхөө жагсаалтыг харах боломжтой.

Огноо	IP хаяг	Төхөөрөмж	Төхөөрөмжийн мэдээлэл	Хандсан тоо	Зөвшөөрөгдсөн эсэх
2022-08-19 09:53:33	192.168.22.12	Компьютер	Mozilla/5.0 (Windows NT 10.0; Win64; x64) AppleWebKit/537.36 (KHTML, like Gecko) Chrome/71.0.3578.98 Safari/537.36	9	БАТАЛГААЖСАН
2022-08-19 09:26:02	202.21.101.226	Гар утас	iPhone14,5	32	БАТАЛГААЖСАН
2022-08-17 17:25:23	202.21.101.226	Гар утас	iPhone14,3	1	БАТАЛГААЖСАН
2022-08-17 17:23:09	202.21.101.226	Гар утас	iPhone14,2	2	БАТАЛГААЖСАН
2022-08-11 21:41:13	66.181.191.235	Гар утас	Mozilla/5.0 (iPhone; CPU iPhone OS 15_6 like Mac OS X) AppleWebKit/605.1.15 (KHTML, like Gecko) Mobile/15E148	6	БАТАЛГААЖААГҮЙ
2022-08-09 20:18:38	66.181.191.235	Гар утас	Mozilla/5.0 (iPhone; CPU iPhone OS 15_6 like Mac OS X) AppleWebKit/605.1.15 (KHTML, like Gecko) Version/15.6 Mobile/15E148 Safari/604.1	1	БАТАЛГААЖСАН

Интернэт банкны хувийн тохиргоо цэсний Хандалтын түүх рүү ороход интернэт банк руугаа ямар төхөөрөмжөөс хандаж байсан мэдээллийг харах боломжтой. Уг цэсэнд таны хамгийн сүүлд нэвтэрсэн **5** төхөөрөмжийн (компьютерийн веб хөтөч, гар утасны веб хөтөч, смарт банк аппликэйшн) мэдээллийг харуулна.

Харилцагч таны интернэт банк руу нэвтэрсэн төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээллийг харуулна. "Зөвшөөрөгдсөн эсэх" талбар нь **баталгаажсан** төлөвтэй бол тухайн төхөөрөмжөөс дахин нэвтрэхэд таниас нэг удаагийн нууц код асуухгүйгээр шууд нэвтэрнэ. Харин **баталгаажаагүй** төлөвтэй тохиолдолд таныг тус төхөөрөмжөөс дахин нэвтрэх үед нэг удаагийн нууц код асуух болно.

Энэхүү 3 цэг дээр дарснаар **Баталгаажсан** эсвэл **Баталгаажаагүй** төлөвтэй төхөөрөмжийг төлөвийг нь өөрчлөх эсвэл жагсаалтаас устгах боломжтой.

Санамж: Жагсаалтанд харагдах 5 төхөөрөмжөөс илүү болсон тохиолдолд таны хамгийн эхэнд нэвтэрсэн баталгаажаагүй 1 төхөөрөмжийг устгагдах болно.